



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 547.7 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Амгалан дулааны станц” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнхөд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулах, хяналт тавьж ажиллах;

2.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай 102 дугаар тогтоолыг мөрдөх, байгууллагын санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлж, орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх, 2016 он, 2017 онд төсөвт төвлөрүүлээгүй 3.0 сая төгрөгийн түрээсийн орлогыг 2018 оны 3 дугаар улиралд багтаан төсөвт төвлөрүүлэх;

2.5. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэх явдлыг зогсоох;

0002229


2.6. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчим, Засгийн газрын 2018 оны Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай 8 дугаар тогтоолыг тус тус мөрдөж ажиллах;

2.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 105 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль зөрчин худалдан авалт хийсэн	Захирал Ш.Баянмөнх Ерөнхий ня-бо Ч.Бямбаа	527,080.5	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 33.1, 33.2 дахь заалтуудыг мөрдөж ажиллах
2	Гэрээ хэлцэлгүй худалдан авсан ажил үйлчилгээ	Захирал Ш.Баянмөнх Ерөнхий ня-бо Ч.Бямбаа	17,641.00	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
3	Төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал Ш.Баянмөнх Ерөнхий ня-бо Ч.Бямбаа	2,964.5	"Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолыг мөрдөх
	Дүн		547,686.0	